



БАТЛАВ  
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАНД ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЦОГСАЙХАН

..... он..... сар..... өдөр

## ДИЗЕЛЬ ТҮЛШ, АВТОБЕНЗИНИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Танилцуулга

Олон улсын болон Монгол улсын стандартын шаардлагад нийцсэн шатахуун нийлүүлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулна.

### 2. Зорилго

Байгууллагын хэрэгцээнд зориулж олон улсын болон Монгол улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг гэрээ байгуулсан өдрөөс нэг жилийн хугацаанд өөрийн ШТС-ын салбар, сүлжээгээр дамжуулан нийлүүлэх байгууллагатай хамтран ажилна.

### 3. Ажлын дэлгэрэнгүй мэдээлэл

д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	АИ-92 бензин	литр	28,411
2	АИ-95 бензин	Литр	4,962
3	Дизель түлш	Литр	2,628

### 4. Нийлүүлэх барааны тоо хэмжээ

4.1. Нийлүүлэх барааны тоо хэмжээ нь төсөвт ертгийн дүнгээс хэтрэхгүй байна. Бараа нийлүүлэлтийг захиалагчийн сар бүрийн бодит гүйцэтгэлээр тооцно.

### 5. Ерөнхий шаардлага

- 5.1. Улаанбаатар хот, 21 аймагт шатахуун түгээгүүрийн газаруудтай байх /MNS 4628 : 2013. Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага/
- 5.2. Шатахууны техникийн үзүүлэлтийг харуулсан баримт бичгийг монгол хэл дээр ирүүлнэ.
- 5.3. Шатахууны нэгжийн үнийг тухайн үед мөрдөгдөж буй зах зээлийн ханшаас өндөр үнээр нийлүүлэхийг хориглох ба энэ талаар баталгаа албан мэдэгдлийг ирүүлнэ.
- 5.4. Шатахууны техникийн үзүүлэлт нь Олон улсын болон Монгол улсын MNS 6861:2020, MNS 0217:2017 стандартын шаардлагыг хангасан байх
- 5.5. Зах зээлд шатахууны хомсдол үүссэн нөхцөлд нийлүүлэгч тал гэрээний үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх шатахууны нөөцтэй байна.
- 5.6. Тухайн шатахууныг үйлдвэрлэгч, зуучлан борлуулагч буюу нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний хуулбар, барааны чанарын сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг заавал хавсаргана.
- 5.7. Орон нутагт байрлах ШТС-ууд нь хоорондоо болон төвтэй Цахим систем буюу онлайннар холбогдсон, худалдан авалт болон төлбөр тооцоог онлайннар хянах боломжтой байх